

“Хүн орчин” хичээлийн ээлжит хичээлийн

Төлөвлөлт \хувилбар 2

Хичээл: Хүн орчин

Анги: 2-р анги

Сэдэв: Ургамал ургахад юу хэрэгтэй вэ?

Зорилго: Сурагчдад ургамал ургахад нөлөөлөх зүйлийн талаар ерөнхий ойлголт өгнө.

Зорилт:

- Зургийг нэрлээд амьд ба амьгүй биеийг ялгах
- Ургамал амьд бие болохыг мэдэх
- Ургамал ургахад хэрэгтэй зүйлсийг ажиглан, ангилан ялгах
- Ургамлыг арчлан хайрлан хамгаалах
- Нэгтгэн дүгнэх

Агуулга:

- ❖ Амьд ба амьгүй бие ажиглан ялгах
- ❖ Ургамал ургахад нар, агаар, ус, хөрс, дулаан хэрэгтэйг мэдэх

Аргазүй:

- Багаар ажиллах арга
- Ажиглалтын арга
- Харилцан ярилцах арга
- Санал бодлоо солилцох арга

Хэрэглэгдэхүүн:

- Өнгийн цаас \ улаан, ногоон\
- Хэрчмэл үг
- Бодит үзүүлэн \ хар шороо, үр, ус, тасалгааны цэцэг\
- Зурагт үзүүлэн\ цэцэг, үүл, хөрс, нар\

Хугацаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа	Хэрэглэг дэхүүн	Анхаарах зүйл
Сэдэлжүүлэх үе 5мин	- Ширээн дээрх зургийг ажиглаад нэрлэнэ. Самбарт амьд ба амьгүй биеийг ялгаж наана. - Амьд бие - Хөдлөнө - Хооллоно - Өснө - Үржинэ - Амьсгална - Амьгүй бие - Хөдлөхгүй - Хооллохгүй - Өсөхгүй - Амьсгалахгүй - Элэгдэнэ	- Баг бүрт хоёр хоёр зураг тарааж өгч сурагчдаар нэрлүүлэн самбарт ялган наана. - Эдгээр зүйлс яагаад амьд бие вэ? - Эдгээр зүйлс яагаад амьгүй бие вэ?	Амьд ба амьгүй биеийн 2 зураг	Амьд ба амьгүй биеийг зөв ялгаж байгааг анхаарах

1. Анхааралтай сонсоно
Амьд бие гэж бодсон хүүхдүүд ногоон, амьгүй гэж бодсон хүүхдүүд улаан карт өргөнө .

2. Өөрийн бодлыг бусдадаа тайлбарлана.

- Ургана
- Цэцэглэнэ
- Услахгүй бол үхнэ
-

Дэвтэр нээж сар өдөр тавина.

Багшийг анхааралтай сонсоно.

Үр , нар, ус, шороо, харандаа, цаас, соронз

Хэрэгтэй зүйлсийг ялган цаасан дээр наана.

-Баг бүрээс 1 хүүхэд гарч тайлбарлана.

Санаа бодлоо солилцоно.

1. Багш карт хэрхэн өргөхийг тайлбарлана.
Амьд бол ногоон Амьгүй бол улаан картаа өргөнө.
Багш гоё ургасан цэцэг харуулна.

2. Энэ цэцэг амьд бие үү?

Амьгүй бие үү?

3. Улаан карт өргөсөн хүүхдүүдээс яагаад амьгүй гэж бодож байна вэ? гэдгийг асууна.

-Ургамал амьд юм бол өнөөдрийн хичээлээр ургамал ургахад юу юу хэрэгтэйг мэдэж авна гэж зорилго, зорилтоо танилцуулна.

-Багуудад өгсөн бодит үзүүлэнгүүдийг нэрлүүлж юу болохыг асууж ярилцана.

- Эдгээр зүйлээс ургамал ургахад юу юу хэрэгтэйг ялган наагаарай

-Багуудын бүтээлийг самбарт байрлуулж тайлбарлуулна.

-Самбарт нар, ус, үр, хөрс, үгсийг хэрчмэл үзүүлэнгээр самбарт байрлуулж ярилцана.

Улаан ногоон өнгийн карт

Савтай цэцэг

Үр, нар, ус шороо, харандаа, цаас, соронз, А4-ийн хэмжээтэй цаас

Хүүхдийн хариултыг сайн сонсох

Алжаал тайлах дасгал 2 мин	Манайхан Өвөө минь гэртээ цэлмэг тэнгэр Эмээ минь гэртээ уудам тал Аав минь гэртээ ханагар уул Ээж минь гэртээ алтан нар Ах минь гэртээ ургаа мод Эгч минь гэртээ гоёхон цэцэг Дүү минь гэртээ бүжин туулай Би өөрөө гоёхон цэцэг	Манайхан шүлгийг багш хөдөлгөөнтэй уншиж өгч сурагчдад зааж өгнө		
Бататгал 5 мин	Багт оноогдсон үзүүлэн дээр өнөөдрийн хичээл дээр юу ойлгосноо багаараа ярилцаж бичээд тайлбарлана.	Багуудад нар, үүл, цэцэг, хөрсний дүрс бүхий үзүүлэн тараан өгч, үзүүлэн дээр ургамал ургахад юу юу хэрэгтэйг бичээрэй гэж дэлгэрэнгүй тайлбарлана.	Цэцэг, нар, үүл, хөрс бүхий зурагт үзүүлэн	Хүүхдийн оролцоог анхаарах
Дүгнэлт 3мин	Цэцэг тарих дадлага ажил хийнэ.	Өнөөдрийн хичээлийг хэрхэн ойлгосноо бататган дадлага ажил хийе.\ Цэцэг тарина\	Ус, шороо, сав үр	Зөв хийж байгааг эсэхэд анхаарах
Гэрийн даалгавар 1 мин	Даалгавар тэмдэглэж авна.	Эцэг эхтэйгээ хамтраад өнгийн цаасаар цэцэг бүтээж ирээрэй		

Хөтөлбөр боловсруулсан:

Б.Нарангарав\ 61 сургууль\	Б.Цэцгээ \ 67 сургууль\
Б.Норов \58 сургууль\	Б.Боржин \ИЦ 1бага
Т.Цэрэнханд \ Эрдмийн өргөө\	Б.Оюунбилэг \ИЦ 2бага\
Г.Ариунтуул \ 18 сургууль\	Г.Баялагмаа \ ИЦ 3 бага\
Д.Лхагвасүрэн \ БМДИ\	Оюунцэцэг \ 24 сургуу
Б.Цэрэндолгор \12сургууль\	

Хүн-Орчин хичээлийн самбарын төлөвлөлт

Ургамал ургахад юу хэрэгтэй вэ?

Сар өдөр

Амьд бие

Амьгүй бие

.....

.....

.....


.....

.....

.....

Сурагчдын

Амьд ба амьгүй биеийн зураг бүтээл



Зурагт үзүүлэн